

ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА

Удиртгал

Шүүхийн шинэтгэлийн үйл явц эрчимтэй өрнөж байгаа энэ цаг үед шинэтгэлийн явцыг эрчимжүүлэх, төгөлдөржүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиар шүүх эрх мэдэл бусад салбараас хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх суурь зохицуулалт, шүүхийн захиргааны байгууллагыг байгуулах эрх зүйн үндсийг тавьсан билээ.

Монгол Улс сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд шүүхийн захиргааны гүйцэтгэх эрх мэдлийн, өөрийн гэсэн хоёр загварыг хэрэгжүүлсэн туршлагадаа тулгуурлан 2013 оноос шүүхийн бие даасан захиргааны загварыг хэрэгжүүлж эхэлсэн энэ цаг үед зарим улс орны шүүхийн захиргааны байгууллагын чиг үүргийн онцлогийг тоймлон авч үзэх, өөрийн улстай харьцуулах зорилгоор энэхүү лавлагааг бэлтгэв. Харьцуулалтын объектийг сонгон авахдаа аль болох бие даасан захиргааны загварыг хэрэгжүүлж буй Хойд Европын өндөр хөгжилтэй зарим улс орнууд, мөн Зүүн Европын пост социалист улсуудыг сонгох Энэ мэдээлэлд шүүхийн захиргааны байгууллагын хэрэгжүүлдэг чиг үүргүүдийг харьцуулалтыг авч үзлээ.

Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл болон шүүх эрх мэдэл хоорондын “зуучлагч”-ийн үүргийг гүйцэтгэх замаар шүүхийн бие даасан байдлыг хангах нь шүүхийн захиргааны байгууллагын үндсэн зорилго юм.¹ Харин энэхүү үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүрэн эрх, чиг үүргийн хувьд харилцан адилгүй байна. Тухайлбал, Франц, Итали зэрэг улсад шүүхийн захиргааны байгууллага зөвхөн шүүгчдийг сонгон шалгаруулах, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг хязгаарлагдмал бүрэн эрхтэй бол Швед, Дани зэрэг улсад шүүхийн захиргааны байгууллага нь шүүхийн төсөв, санхүү, дэд бүтэц, шүүгчдийн боловсролын талаар харьцангуй өргөн бүрэн эрхтэй байна.

Европын улсуудад 2000 оноос хойш шүүхийн захиргааны гүйцэтгэх эрх мэдлийн загвараас бие даасан шүүхийн захиргааны байгууллагыг байгуулах үйл явц эрчимтэй өрнөж байна. Тухайлбал, Ирландад 1998 онд, Дани улсад 1999 онд, Нидерланд болон БНЧУ-д шүүхийн захиргааны бие даасан, мэргэшсэн байгууллагыг байгуулах, төлөвшүүлэх үйл явц эрчимтэй өрнөж байна.² Европын улсуудын хувьд шүүхийн захиргааны байгууллагын гурван загварыг доктор Пим Алберс өөрийн судалгаандаа дурджээ. Нэгдүгээрт, Хойд Европын загвар (Швед, Дани, Ирланд) буюу шүүхийн захиргааны бие даасан байгууллага нь шүүхийн санхүү, төсөв, дэд бүтэц, удирдлага,

¹ European Commission for the Efficiency of Justice, ‘Councils for the Judiciary in EU countries’, Prof. Wim Voermans and Dr Pim Albers, p. 9, 2003

² Мөн тэнд

хяналт, шүүгчдийг томилох, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг өргөн эрхтэй. Хоёрдугаарт, Өмнөд Европын загвар (Итали, Франц) буюу шүүхийн захиргааны байгууллага нь зөвхөн шүүгчийг томилоход зөвлөх, сахилгын шийтгэл хүлээлгэх бүрэн эрхтэй. Гуравдугаарт, “Бусад” буюу шүүхийн захиргааны бие даасан байгууллагагүй бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл нь шүүхийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлдэг (ХБНГУ, Нидерландын вант улс) загвар байна.

Шүүхийн захиргааны хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг АНУ-ын Шүүхийн захиргааны үндэсний холбооноос гаргасан материал³-д дараах байдлаар тодорхойлжээ:

1. **Шүүхийн хүний нөөцийн удирдлагын чиг үүрэг** – шүүх эрх мэдлийн салбарт ажиллагсдыг сонгон шалгаруулах, дадлагажуулж сургах, зөвлөмжөөр хангах, ёс зүйн стандартыг тогтоох, хөдөлмөрийн хөлс, цалинг тодорхойлох, мэргэжлийн түвшинг үнэлж дүгнэх.
2. **Шүүхийн санхүүгийн удирдлагын чиг үүрэг** – шүүхийн санхүүг төлөвлөх, удирдлагаар хангах, шүүхийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн хяналт шалгалт явуулах, төсөв захиран зарцуулсан талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнах;
3. **Хэргийн хөдөлгөөний удирдлагын чиг үүрэг** – шүүх дэх хэргийн ачааллыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, хэргийн хөдөлгөөнийг хурдан шуурхай явуулах арга замыг тодорхойлж, хэрэгжүүлэх;
4. **Шүүхийн мэдээллийн технологийн удирдлагын чиг үүрэг** – шүүхийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр технологийн дэвшлийг үр нөлөөтэй ашиглах арга замыг тогдорхойлохтой холбоотой чиг үүрэг. Мэдээллийг түргэн шуурхай дамжуулах, хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх үүднээс энгийн хэрэглээний компьютер болон бусад тоног төхөөрөмжийг ашиглан шүүхийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэхэд чиглэнэ.
5. **Мэдээллийн удирдлагын чиг үүрэг (Information management)** – шаардлагатай үед шаардлагатай мэдээллийг шийдвэр гаргагчид түргэн шуурхай боловсруулж танилцуулах, шүүхийн үйл ажиллагааны түвшин зорилтот түвшинд байгаа эсэхэд хяналт хийх /мониторинг/, шүүхийн захиргааны ажилтнуудыг шаардлагатай мэдээлээр хангах, өмгөөлөгч, хэргийн оролцогч, төрийн захиргааны байгууллага, олон нийтэд шүүхийн үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах чадавхийг бэхжүүлэх зорилготой функц юм.
6. **Тангарагтан/иргэдийн төлөөлөгчийн удирдлагын чиг үүрэг** – тангарагтан/иргэдийн төлөөлөгчийн шүүн таслах ажиллагаанд оролцох оролцоог үр нөлөөтэй болгоход чиглэнэ.

³ National Association for Court Administration ‘The Court Administrator’s Manual’, p. 5-6
Цахим холбоос: [http://www.fjc.gov/public/pdf.nsf/lookup/court_admin.pdf/\\$file/court_admin.pdf](http://www.fjc.gov/public/pdf.nsf/lookup/court_admin.pdf/$file/court_admin.pdf)

7. **Дэд бүтцийн удирдлагын чиг үүрэг** – шүүхийн үйлчилгээний чанартай, жигд хүртээмжтэй түгээх үүднээс шүүхийг хэвийн ажиллахад шаардлагатай хангалттай барилга байгууламж, тоног төхөөрөмж зэрэг хатуу дэд бүтцээр хангасан байх нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэн хадгалах нэг чухал арга зам юм.
 8. **Төрийн бусад эрх мэдлийн байгууллагатай харилцах "төлөөлөгч" (Liaison)-ийн чиг үүрэг** – төрийн бусад эрх мэдлийн байгууллагуудтай өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд харилцах, хамтран ажиллах
 9. **Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиг үүрэг** – олон нийтийг шүүхийн тухай мэдээллээр тогтмол хангах, шүүхийн тогтолцооны тухай болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл явдлын талаар мэдээллийг цуглуулах чиг үүрэг.
 10. **Судалгаа, зөвлөмжөөр хангах үйлчилгээний чиг үүрэг** – шүүхийн захиргааны зохион байгуулалтын болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудлыг олж тогтоох, шийдвэрлэх хувилбар, арга замыг дэвшүүлэх зорилготой чиг үүрэг.
 11. **Туслах чиг үүрэг** – шүүхийн захиргааны институт /хороо, комисс, зөвлөл гэх мэт/ -ийг хэвийн үйл ажиллагаагаа явуулахад нь захиргааны дэмжлэг үзүүлэх
- 1. Шүүхийн захиргааны чиг үүрэг: Зарим улсын жишээн дээр**

1.1. Бүгд найрамдах Серби улсын шүүхийн захиргаа

Тус улсад шүүхийн захиргааны бие даасан байгууллагыг байгуулах эрх зүйн үндсийг Үндсэн хуулийн 153 дугаар зүйлд “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллага нь Шүүхийн дээд зөвлөл байна” гэж тодорхойлсон. Улмаар Зөвлөлийн бүтэц зохион байгуулалт, бүрэн эрх, чиг үүргийг Шүүхийн дээд зөвлөлийн тухай хуульд нарийвчлан зохицуулж байна. Шүүхийн дээд зөвлөл нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ улсын нэгдсэн төсвөөс санхүүжих бөгөөд шүүхийн төсвийг хуваарилах онцгой бүрэн эрхтэй.⁴ Шүүхийн дээд зөвлөл нь нийт 11 гишүүнээс бүрдэх бөгөөд Дээд шүүхийн ерөнхийлөгч, хууль зүйн сайд, Үндэсний ассемблейн хууль зүйн байнгын хорооны дарга нар албан тушаалаараа, үлдсэн 8 гишүүнийг Үндэсний ассемблейгаас томилох замаар гишүүдийг бүрдүүлнэ.⁵ Шүүхийн дээд зөвлөл нь хуулиар олгосон дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна:

- Шүүгчийг сонгон шалгаруулах;
- Шүүгчийг огцруулах талаар шийдвэр гаргах;
- Үндэсний ассемблейд шүүгчийг томилуулах тухай санал хүргүүлэх;

⁴ Бүгд найрамдах Серби улсын Шүүхийн дээд зөвлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйл, цахим холбоос: <http://www.refworld.org/pdfid/4b55cce92.pdf>

⁵ Мөн хуулийн 5 дугаар зүйл

- Дээд шүүхийн тэргүүн шүүгч /Ерөнхийлөгч/-ийг томилох, чөлөөлүүлэхээр Үндэсний Ассемблейд санал хүргүүлэх;
- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилуулахаар нэр дэвшигчийг Дээд шүүхэд санал болгох;
- Иргэдийн төлөөлөгч /lay judge/-ийг сонгон шалгаруулж томилох;
- Шүүгчийг сэлгэн ажиллуулах, албан тушаалаас огцруулах асуудлыг шийдвэрлэх;
- Ерөнхий шүүгч, шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг тогтоох;
- Шүүгчийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн, бүтэц, гишүүдийг томилох, чөлөөлөх, ажиллах журмыг тогтоох;
- Шүүгч, шүүхийн захиргааны ажилтныг мэргэшүүлж, дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Шинээр томилогдсон шүүгчдийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлах;
- Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах;
- Шүүх тус бүрт ажиллах шүүгч, иргэдийн төлөөлөгчийн орон тоог батлах;
- Шүүхийн захиргааны чиг үүргийг хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх;
- Шүүгч, шүүхийн дээд зөвлөлийн гишүүдийн хараат бус байдлыг хангах чиглэлээр шийдвэр гаргах;
- Шүүхийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай төсвийг боловсруулж өргөн мэдүүлэх, төсвийн зарцуулалтад хяналт тавих;
- Ажлын алба, чиг үүргийн хороодыг байгуулах;
- Шүүхийн үйл ажиллагаа, шүүгчийн бүрэн эрх, чиг үүрэг болон шүүн таслах ажлыг эрхлэн явуулахад хамааралтай хуулийн төсөлд санал өгөх;
- Шүүгчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан гэм хорыг нөхөн төлөх талаар шийдвэр гаргах;
- Үндэсний ассемблейд өөрийн үйл ажиллагааг жил тутам тайлагнах;
- Үндэсний шүүхийн шинэтгэлийн баримт бичигт заасны дагуу өөрт харьяалуулсан ажлыг гүйцэтгэх;
- Олон нийтэд үйл ажиллагаагаа тайлагнах;
- Гадаад улсын шүүхийн захиргааны байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- Хууль тогтоомжид заасны дагуу хэм хэмжээний акт батлан гаргах.

1.2. Ирландын шүүхийн зөвлөл /The Irish Council for the Judiciary/

ИБУИНВУ-д 1924 онд тусгаар тогтнолоо зарлан тунхагласнаас хойш Шүүхийн тухай хуулийн дагуу шүүхийн захиргааны чиг үүргийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу хууль зүйн яам хэрэгжүүлж байв. Гүйцэтгэх эрх мэдлийн загварыг 70 гаруй жил хэрэгжүүлсний эцэст 1990-ээд оны дунд үед шүүхийн захиргааны үр нөлөөг

дээшлүүлэх асуудал чухлаар тавигдсан.⁶ Улмаар 1998 онд “Шударга ёсны үйлчилгээний тухай хууль” /Courts Services Act/-баталж бие даасан Шүүхийн зөвлөлийн ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Зөвлөлийг Дээд шүүхийн тэргүүн шүүгч эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд удирдах бөгөөд гишүүдийг шат шатны шүүхийн шүүгчид, хууль зүйн яам, хууль зүйн мэргэшлийн төлөөлөл, шүүхийн захиргааны ажилтан, шүүхийн үйлчлүүлэгчдийн төлөөлөл, үйлдвэрчний эвлэлийн төлөөллөөс бүрдүүлдэг. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх нарийн бичгийн дарга хариуцна.

Шүүхийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар шүүхийн захиргааны дараах чиг үүргийг зөвлөл хэрэгжүүлнэ:

- а. шүүхийг удирдлагаар хангах /manage the courts/
- б. шүүгч шүүн таслах чиг үүргээ хэвийн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- в. Шүүхийн тогтолцоо, үйл ажиллагааны тухай мэдээллийг олон нийтэд хүргэх
- г. шүүхийг барилга байгууламж, тоног төхөөрөмжөөр хангах, арчлан хамгаалах
- д. шүүхээр хүртээмжтэй үйлчлүүлэх бололцоогоор хангах /provide facilities for court users/

Шүүхийн зөвлөл дээр дурдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга ажиллагааг мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан байна:

- а. Шүүхийн байр байрлах газар болон бусад өмчлөлийн зүйлийг эзэмших
- б. чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гэрээ хэлцэл байгуулах
- в. шүүхийн хүний нөөцийг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх
- г. шүүхээр үйлчлүүлэгч иргэдийн саналыг сонсох тогтолцоог бүрдүүлэх
- д. хууль зүйн сайдын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар шүүхийн үйлчилгээний хураамж, төлбөрийн зохистой хэмжээг тогтоох талаар хууль зүйн сайдад зөвлөх
- е. Хууль зүйн сайдад шүүхийн маргааны харьяаллыг тогтоох болон шүүх хоорондын үйл ажиллагааны талаар зөвлөмж, санал гаргах
- ё. өөрийн үйл ажиллагааны түвшинг хууль зүйн сайдтай зөвшилцсөний дагуу эксперт, мэргэжилтнээр тогтоолгох
- ж. төрийн байгууллагын дансыг хууль тогтоомжид заасны дагуу эзэмших
- з. шүүхийн харьяаллыг тогтоох

⁶ 1995 оны 10 дугаар сард Хууль зүйн сайдын тушаалаар шүүхийн захиргааны үр нөлөөтэй чиглэлийг тодорхойлох чиглэлээр байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсэг Ирландын шүүхийн тогтолцооны нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, нэн тэргүүнд шүүхийн захиргааны бие даасан, мэргэшсэн байгууллагыг байгуулахыг зөвлөмж болгожээ.

P.J. Fitzpatrick, “Management of the Courts: the Irish Experience” 2008, p. 1

Ирландын шүүхийн зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээг хуулиар нарийвчлан тодорхойлсон ч бие даасан шүүхийн захиргаатай улсын хувьд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нөлөө хүчтэй хэвээр байна.⁷

1.3. Польш улсын Шүүхийн үндэсний зөвлөл

Тус улсын 1952 оны Үндсэн хуульд шүүх хараат бус байх зарчмыг тусгасан ч түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн болон институцийн механизм хангалттай бус байв. Улмаар 1990-ээд онд өрнөсөн өөрчлөлт, шинэлчлэлийн үйл явцын хүрээнд шүүхийн хараат бус байдлыг хангаж хамгаалах асуудал чухлаар тавигдсантай зэрэгцэн шүүхийн захиргааны мэргэшсэн, бие даасан байгууллагыг байгуулах санал, санаачилга гарч эхэлсэн нь Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, цаашлаад Шүүхийн үндэсний зөвлөлийн хуулийг батлан гаргах ажлын эхлэл байв. 1989 оны 12 дугаар сарын 20-ны өдөр шүүхийн хараат бус байдлыг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй Шүүхийн үндэсний зөвлөлийн хуулийг батлан гаргав. Тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т зааснаар Шүүхийн үндэсний зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

а. Дээд шүүх болон бусад шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаар дүгнэлт гаргах

б. дээд шүүх болон бусад шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг томилуулах талаар Ерөнхийлөгчид уламжлах

в. шүүгчийн ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх

г. шүүх, шүүгчтэй холбоотой асуудлаар ерөнхийлөгч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд байр сууриа илэрхийлэх

д. өндөр насны тэтгэвэрт гарах тухай шүүгчдийн хүсэлтийг хүлээн авч уламжлах

е. шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөн эрх зүйн хэм хэмжээний төслийг боловсруулахад саналаа уламжлах

ё. шинэ шүүгчдийн болон шүүгчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийн талаар байр сууриа илэрхийлэх

ж. шүүгч, шүүхийн захиргааны ажилтны сургалтын хуваарийн талаар байр сууриа илэрхийлэх

з. өндөр насны тэтгэвэрт гарсан шүүгчийг эргүүлэн шүүгчээр томилох асуудлыг судлах, саналаа уламжлах

и. ердийн шүүх, цэргийн шүүх дэх шүүгчийн ёс зүйн хорооны даргыг томилох

к. ердийн шүүх, цэргийн шүүхийн ерөнхий шүүгчийг томилох, чөлөөлөх талаар саналаа уламжлах

л. улсын ерөнхий прокурорын албан тушаалд нэр дэвшигчийг санал болгож уламжлах

м. Шүүх, прокурорын сургуулийн хөтөлбөр хариуцсан зөвлөлийн 3 гишүүнийг томилох

⁷ European Commission for the Efficiency of Justice, 'Councils for the Judiciary in EU countries', Prof. Wim Voermans and Dr Pim Albers, p. 38, 2003

н. Шүүх, прокурорын сургуулийн захирлыг томилоход санал өгөх

1.4. Унгар улсын шүүхийн захиргаа

Хуучин социалист улсуудад 1989-1990 онд өрнөсөн их өөрчлөлт, шинэчлэлийн дотор шүүхийн шинэтгэлийн үйл явц томоохон байр суурийг эзэлж байлаа. Социалист тогтолцооны үед шүүх эрх мэдэл нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс үлэмж хамааралтай байсан туршлагыг халах үүднээс Хууль зүйн сайд болон Дээд шүүхийн ерөнхий шүүгчид харьяалуулж байсан шүүхийн захиргааны чиг үүргийг бие даасан шүүхийн захиргааны байгууллага болох Шүүхийн үндэсний зөвлөлд шилжүүлэв. Улмаар Дээд шүүхийг шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэгч болгон зохион байгуулжээ. Шүүхийн үндэсний зөвлөлд үлэмж эрх мэдэл шилжүүлсэн хэдий ч Зөвлөлийн даргын албан үүргийг Дээд шүүхийн ерөнхий шүүгч хавсран эрхэлж байсан нь /аль аль нь орон тооны албан тушаал/ олон асуудлыг дагуулж, хэргийн ачаалал шүүхүүдэд харилцан адилгүй, түдгэлзсэн хэрэг, хойшлуулсан шүүх хуралдааны тоо үлэмж нэмэгдсэн нь шүүхийн захиргааны тогтолцоог шинэчлэх үндэс болжээ. Улмаар хууль тогтоогч шүүхийн захиргааны үндсэн чиг үүргийг Шүүхийн захиргааны үндэсний байгууллагын Ерөнхийлөгч хэрэгжүүлэхээр институцийн өөрчлөлт хийж, харин хяналт тавих бүрэн эрхийг Шүүхийн үндэсний зөвлөлд Шүүхийн захиргааны тухай хуулиар олгосон байна. Энэ зохицуулалт 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.⁸

Энэхүү институцийн өөрчлөлтийн хүрээнд шүүхийн захиргааны чиг үүргийг хоёр тусгаарлан зааглажээ. Шүүхийн захиргааны үндсэн чиг үүргийг Шүүхийн захиргааны үндэсний байгууллагын Ерөнхийлөгч хэрэгжүүлэх бол түүний үйл ажиллагаанд Шүүхийн үндэсний зөвлөл хяналт тавихаар заажээ.

Шүүхийн захиргааны төв байгууллагын Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ⁹:

А. Шүүхийн төсөв, санхүүгийн чиглэлээр:

1. шүүхийн төсвийг Дээд шүүхийн саналыг авсны дагуу төлөвлөж Засгийн газарт уламжлах. Засгийн газар нь шүүхийн **төсвийг өөрчлөхгүйгээр улсын нэгдсэн төсвийн төсөлд багтаан парламентад өргөн мэдүүлнэ;**

2. шүүхийн төсвийг парламентийн төсвийн байнгын хороогоор хэлэлцэхэд оролцох

3. шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд санхүүгийн жилд төсвийн хуваарилалтыг хийх

4. шүүхийг санхүүгийн удирдлагаар хангах

⁸ Унгар улсын Үндсэн хуулийн шүүхийн албан ёсны вэбсайт <http://www.lb.hu/en/english/judicial-reform>

⁹ БНУУ-ын “Шүүх, шүүхийн захиргааны тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэг

Цахим холбоос: [http://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF\(2012\)007-e](http://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF(2012)007-e)

5. шүүхийн санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх
6. жил тутмын төсөвт шүүх эрх мэдлийн салбарт ажиллагсдын цалингаас бусад эрсдлийн сангийн хуваарилалтыг хийх /олговор, гэм хорыг нөхөн төлөх гэх мэт/

Б. Шүүхийн статистик мэдээ цуглуулах, хэргийн ачааллыг судалж хуваарилах чиглэлээр:

1. шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ачаалал, төсвийн хууль тогтоомжид нийцүүлэн шүүх бүрт ажиллах шүүгчийн орон тоог тогтоох
2. шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд, түргэн шуурхай явуулах зорилгоор хэргийг харьяаллын шүүхээс өөр шүүхэд шилжүүлэх
3. яаралтай шийдвэрлэхгүй тохиолдолд нийтийн ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй тохиолдолд тодорхой хэргийг шууд хянан шийдвэрлүүлэх тухай шийдвэр гаргах
4. шүүхийн статистик мэдээллийг цуглуулж, боловсруулах
5. жилд нэгээс доошгүй удаа шүүн таслах ажлын статистик мэдээг дагнасан шүүхийн төрлөөр болон шүүхийн тогтолцооны шат тус бүрээр судлан гаргах, шаардлагатай тохиолдолд арга зүйг шинэчлэх,

В. Шүүхийн хүний нөөцийг удирдах чиглэлээр:

1. шүүгчийн сул орон тоог нийтэд зарлах
2. шүүгчид нэр дэвшигчийг томилуулах, шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх тухай Ерөнхийлөгчид уламжлах
3. шүүгчийн албан тушаалд сонгон шалгаруулах
4. цэргийн шүүхийн шүүгчийг томилох, бүрэн эрхийн хугацааг дуусахад ердийн шүүгчийн албан тушаалд томилуулах
5. шүүгчийг шилжүүлэн ажиллуулах шийдвэрийг гаргах
6. шүүгчийг **шүүн таслах ажлын төрлөөр сэлгүүлэн ажиллуулах**
7. шүүгчийг гадаад улсад урт хугацаагаар ажиллуулах тухай шийдвэр гаргах
8. шүүхийг татан буулгасан тохиолдолд тухайн шүүхийн шүүгчийг цааш ажиллуулах шүүхийг тогтоох
9. шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан эсхүл шүүгчээр ажиллах насны дээд хязгаарт хүрсэн тохиолдолд хуульд заасны дагуу урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр албан тушаалаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх
10. хуульд заасны дагуу шүүгчийг тухайн шүүхийн ерөнхий шүүгчээр томилох, чөлөөлөх
11. шүүхийн ерөнхий шүүгч болон түүний удирдлагад ажиллаж байгаа шүүгч, ажилтан хооронд ашиг сонирхлын зөрчил үүссэн бол шилжүүлэх
12. шүүхийн иргэдийн төлөөлөгчийн жишиг тоог тухайн засаг захиргааны нэгжийн хүн амын тоо, цөөнх бүлгийн тоонд тус тус үндэслэн тогтоох

Г. Шүүхийг захиргааны удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд:

1. бүх шатны шүүхийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хэм хэмжээ, стандартыг тогтоох
2. бүх шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үе шат, хугацааны дотор явуулж байгаа эсэхэд хяналт тавих
3. шүүхийн ерөнхий шүүгчдийг хянан шалгах
4. энэ хэсгийн 2 болон 3 дахь хэсэгт заасан шалгалтын үр дүнд үндэслэн сахилгын шийтгэл оногдуулах

Д. Шүүхийн сургалтын чиглэлээр:

1. шүүхийн сургалтын үндсэн чиглэл, хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих
2. шүүхийн сургалтын дүрэм журмыг батлах

Е. Мэдээллээр хангах, тайлагнах чиглэлээр:

1. Шүүхийн үндэсний зөвлөлд 6 сар тутам ажлаа тайлагнах
2. Дээд шүүхийн ерөнхий шүүгч, анхан, давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчдэд жил тутам ажлаа тайлагнах
3. Парламентад шүүхийн тогтолцооны нөхцөл байдал, шүүхийн захиргааны хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар тайлагнах
4. хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангах зорилгын хүрээнд хууль зүйн сайдын хүсэлтийн дагуу мэдээлэл гарган өгөх
5. шүүхийн тогтолцоо, захиргааны үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн хэм хэмжээг боловсруулахад хууль зүйн сайдын хүсэлтийн дагуу санал өгөх

Ж. Бусад чиг үүргийн хүрээнд:

1. шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулиар тогтоосон хугацаанд нэгтгэн гаргах
2. шүүхийн шагнал, цол олгох
3. өөрийн чиг үүргийн хүрээнд шүүхийн хэвийн, тасралтгүй чиг үүргээ хэрэгжүүлэх бололцоогоор хангах

1.5. Литва улсын шүүхийн захиргаа

Литва улс нь шүүхийн захиргааны өөрийн загварыг хэрэгжүүлдэг.¹⁰ Шүүхийн өөрийн захиргааны тогтолцоо нь нийт шүүгчдийн зөвлөгөөн, Шүүхийн зөвлөлөөс бүрдэх

¹⁰ Литва улсын Шүүхийн тухай хуулийн 113 дугаар зүйл “Шүүхийн захиргааны чиг үүргийг шүүгчид бие даан өөрийн хариуцлагаар хэрэгжүүлнэ”

бөгөөд шүүхийн захиргааны өдөр тутмын үйл ажиллагааг шүүхийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Нийт шүүгчдийн зөвлөгөөн нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ¹¹:

1. Нийт шүүгчдийн зөвлөгөөний дэгийг батлах
2. Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах
3. Шүүхийн зөвлөлийн гишүүдийг томилох
4. Шүүхийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх
5. Шүүхийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тогтоол гаргах

Шүүхийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ¹²:

1. Шүүхийн зөвлөлийн дарга, орлогч даргыг нууц санал хураалтаар сонгох
2. Шүүхийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг батлах
3. Шүүгчийн албан тушаалд томилох, дэвшүүлэн томилох, шилжүүлэх, огцруулах, чөлөөлөх асуудлаар ерөнхийлөгчид үндэслэл бүхий санал уламжлах
4. Шүүхийн ерөнхий шүүгчийг томилох, чөлөөлөх асуудлаар ерөнхийлөгчид санал уламжлах
5. Шүүхийн орон тоог нэмэгдүүлэх, багасгах асуудлаар ерөнхийлөгчид үндэслэл бүхий санал уламжлах
6. Шүүгч сонгон шалгаруулах орон тооны хорооны гишүүдийг томилох, үйл ажиллагааны дүрмийг батлах
7. Шүүгчийн ёс зүйн хорооны дарга, гишүүдийг нууц санал хураалтаар томилох
8. Шүүхийн ёс зүйн хороо болон бусад шүүхийн захиргааны институцийн тайланг хэлэлцэх
9. Шүүгчийн ёс зүйн зөрчилд хэрэг үүсгүүлэх
10. Шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагааны түвшинг үнэлж дүгнэх хороог байгуулах, үйл ажиллагааны журам батлах
11. Шүүгчийг мэргэшүүлэх үндэслэл, журмыг тогтоох, улмаар шүүгчид хэрэг хуваарилах журмыг тогтоох
12. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журмыг батлах
13. Шүүгч, шүүхийн захиргааны ажилтны сургалтын хөтөлбөр, хуваарийг батлах
14. Бүх шатны шүүхийн бүтэц, орон тоо, ажлын байрны тодорхойлолтын загварыг батлах
15. Шүүхийн төсвийг хэлэлцэн баталж, Засгийн газарт уламжлах
16. Шүүхийн захиргааны төв байгууллагын тайланг хэлэлцэх
17. Жил бүрийн 3 дугаар сарын 31-нээс өмнө шүүхийн захиргааны төв байгууллагын тайланг хэлэлцэж гаргасан дүгнэлтийг өөрийн цахим хуудаст байршуулах
18. Нийт шүүгчдийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг зарлан зохион байгуулах

¹¹ Мөн хуулийн 117 дугаар зүйл

¹² Хуулийн 120 дугаар зүйл

19. Шүүхийн үйл ажиллагаатай холбоотойгоор бусад байгууллага, албан тушаалтантай харилцах
20. Шүүхийн захиргааны чиглэлээр гадаад улсын болон олон улсын байгууллагатай харилцах
21. Хууль тогтоомжоор олгосон бусад бүрэн эрх

Шүүхийн захиргааны байгууллага (National Courts Administration) дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах
2. Өөрийн бүрэн эрхийн хүрээнд нийт шүүхийг шүүхийн өөрийн захиргааны институтуудтэй холбох
3. Шүүхийн өөрийн захиргааны институтуудыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
4. Шүүхүүдийг тоног төхөөрөмж, барилга байгууламж, тээвэр, холбоо, дэд бүтэц зэрэг нэгдсэн материаллаг дэмжлэгээр хангах
5. Шүүгчийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх
6. Шүүхийн төсвийг хэмнэлттэй байх зарчмыг удирдлага болгон үндэслэлтэйгээр төлөвлөх
7. Шүүхийн мэдээллийн системийн талаар баримтлах стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх
8. Шүүхийн тогтолцоог үр нөлөөтэй ажиллах арга замыг тодорхойлох

2. Дүгнэлт

Шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангах үндсэн зорилготой шүүхийн захиргааны байгууллагын чиг үүрэг төрийн захиргааны бусад байгууллагатай харьцуулбал ихээхэн онцлогтой. АНУ-ын Дээд шүүхийн нэгэн шүүгч "шударга ёсны үйлчилгээний чанар сайн шүүгчтэй байсан ч сайн менежергүй бол сайжрахгүй" гэснээс үзвэл шүүхэд сайн менежер буюу сайн захиргаа байх шаардлагатай.

Шүүхийн захиргааны байгууллагын хэрэгжүүлж буй чиг үүрэг тухайн улсын шүүхийн захиргааны загвараас хамаарч харилцан адилгүй байна. Европын зарим улс Унгар, Литва зэрэг улсад шүүхийн захиргаа нь харьцангуй өргөн чиг үүрэгтэй буюу шүүхийн төсөв, санхүү, захиргаа, хүний нөөц зэрэг асуудлыг хариуцаж байхад төв Европын Франц, Итали зэрэг улсад шүүхийн захиргааны байгууллага нь голчлон гүйцэтгэх эрх мэдэлд "найдсан", Ирланд, Польш, Серби зэрэг улсад шүүхийн захиргаа нь гол төлөв шүүхийн хүний нөөцийн удирдлагын чиг үүргээр шүүхийн захиргааны байгууллагын чиг үүрэг хязгаарлагдаж байна.

Зүүн Европын улс орнуудад 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхэн үед буюу харьцангуй сүүлд байгуулсан шүүхийн захиргааны байгууллагуудыг гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлаж, бие даасан байдлыг нь хангах хандлага түгээмэл ажиглагдаж байна. Польш, Унгар, Литва зэрэг улсад шүүхийн захиргааны өөрийн удирдлага буюу

нийт шүүгчдийн хуралдаан, түүнээс томилогдсон зөвлөл, шүүхийн захиргааны гүйцэтгэх байгууллага нь Засгийн газраас харьцангуй хараат бус ажиллах эрх зүйн үндсийг тусгажээ.

Монгол улсын хувьд шүүхийн захиргааны мэргэшсэн, дээд байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүргийг хууль тогтоомжид харьцангуй өргөн хүрээнд тусгасан боловч дараах онцлог чиг үүргийг хэрэгжүүлдэггүй:

1.Польш болон зүүн Европын зарим улсуудын ерөнхий прокурорын албан тушаалд нэр дэвшигчийг санал болгож уламжлах,

2.Хэргийн хөдөлгөөний чиглэлээр шаардлагатай тохиолдолд хянан хэлэлцэгдэж буй хэргийг нийтийн ашиг сонирхлын тулд, эсхүл хуульд заасан хугацааны дотор шийдвэрлүүлэхээр адил шатны өөр шүүхэд шилжүүлэх, эсхүл шууд шүүх хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх /Унгар улсын туршлага/

Харин Монгол улс өөрийн туршлага, ололт амжилтандаа тулгуурлан шүүхийн захиргааны чиг үүрэгтэй холбогдох хуулийн зарим хэм хэмжээг тодруулах, эсхүл жишиг практикийг тогтооход дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай⁵

1. Шүүхийн захиргааны чиг үүргийг зөвхөн шүүхийн захиргааны байгууллага л хэрэгжүүлж байгааг анхааралтай судлан үзэх. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд холбогдох дүрэм (Шүүгчийн ёс зүйн дүрмээс бусад), журам, бодлогыг мэргэшсэн, төлөөллийн¹³ байгууллага болохын хувьд шүүхийн захиргааны байгууллага шууд баталж мөрдүүлж байна. Өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг дүгнэн шинжилбэл "Шүүгч сонгон шалгаруулах журам", "Мэргэшлийн хорооны дүрэм", "Шүүгчийн ёс зүйн хорооны дүрэм"-ийг Ерөнхийлөгч, "Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг дүгнэх журам"-ыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч тус тус баталж байна. Энэ нь шүүхийн захиргааны өөрийнх бие даасан байдлыг хөндөх төдийгүй бодлоголо хэрэгжүүлэх хэрэгсэл болсон дүрэм журам нь өөр этгээдээр батлагдах нь улс төрийн хувьд хараат байдлыг бий болгож байна.

2.Шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөх, өргөн мэдүүлэх хүрээнд Унгар улсын туршлагыг нэвтрүүлэх нь улсын төсвийн нэгдмэл байдлыг хангах ач холбогдолтой байж болохоор байна. Өөрөөр хэлбэл шүүхийн захиргааны байгууллага нь шүүхийн төсвийг үндэслэлтэй, оновчтой төлөвлөж Засгийн газарт хүргүүлэх, **Засгийн газар нь шүүхийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн төсвийг бууруулахгүйгээр** улсын нэгдсэн төсвийн төсөлд тусгаж, парламентанд өргөн мэдүүлэх механизмыг тодорхой болгосон байна. Мөн шүүхийн төсвийг парламент дээр Шүүхийн захиргааны байгууллага хэлэлцүүлдэг.

3.Унгар улсын Хэргийн хөдөлгөөний менежментийг шүүхийн хүний нөөцийн удирдлагатай нягт уялдаатай хэрэгжүүлж шүүхийн ажлын ачааллыг шийдвэрлэдэг

¹³ Шүүгчдийн төлөөллөөс бүрдсэн байгууллага болохын хувьд

туршлага байна. Шүүх дэх шүүгчийн орон тоог тухайн шүүхийн хэргийн ачааллыг судалсны үндсэн дээр өөрчлөн тогтоох чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Нэгтгэн дүгнэвэл дэлхийн улс орнууд өөрийн улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүйн болон шүүхийн тогтолцооны хэв шинж, онцлогт тохирсон, "сайн" гэж хэлэгдэх шүүхийн захиргааны байгууллагыг байгуулах нь нийтлэг хандлага болсон байна.

